

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
2018 ОНЫ III УЛИРЛЫН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.10.02

Нэг.Ерөнхий зүйл

1.1 2018 онд 4,172 тэрбум төгрөгийн 40 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 3 дугаар улирлын байдлаар буюу 10 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 3,582 тэрбум төгрөгийн 37 худалдан авалтанд 3,406 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдаж 169,2 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Мөн өдрийн байдлаар зарлагдаж буй 50 сая төгрөгийн 1, зураг төсөв хүлээгдэж буй буюу 540 сая төгрөгийн 2 худалдан авалт тус тус зохион байгуулагдахаар хүлээгдэж байна.

2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,067 тэрбум төгрөгийн 8 ажлын эрх шилжиж ирсэн бөгөөд бүгд тендер шалгаруулалт дууссан байна.


Тус худалдан авалтуудаас 36 тендерийг цахим хэлбэрээр зарлан зохион байгуулж, онцгой нөхцөл байдал үүссэний улмаас аймгийн хэрэгцээнд экскаватор болон Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашиныг захиалагч шууд худалдан авч гэрээ байгуулагдсан.

Төлөвлөгөөний биелэлт **95%**-ийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүжилтийн товчоон



Санхүүжилтийн эх үүсвэрийг графикаар харуулбал




Нийт зохион байгуулах 40 худалдан авалтаас нээлттэй тендер шалгаруулалтын 13, харьцуулалтын 23, зөвлөх үйлчилгээний 2, шууд худалдан авах 2 худалдан авалт байна. Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмыг санхүүжилт тус бүрээр харуулбал.

Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам



Худалдан авах ажиллагааны төрөл



	Улсын төсөв /байгууллагын захиалгаар/	Орон нутгийн хөгжлийн сан	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Орон нутгийн хөрөнгөөр	Замын сангийн хөрөнгөөр
■ Ажил	1	5	7	3	2
■ Бараа	10	4	1	5	

1.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй хийгдсэн худалдан авалт байхгүй болно

1.3 2018 оны III улиралд зохион байгуулахаар төлөвлөгдсөн худалдан авалтуудаас, техникийн тодорхойлолт ирүүлэгүйн болон бусад шалтгааны улмаас зохион байгуулагдаагүй хүлээгдэж байгаа Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын үргэлжлэл болон өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх худалдан авалтуудыг 2018 оны IV улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.

1.4 2018 оны III улирлын байдлаар зохион байгуулагдан хийгдсэн бүх тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд зохион байгуулсан бөгөөд тендер нээснээс хойш 14 хоногт багтаан үнэлгээ хийгдээгүй 7 тендер шалгаруулалт байна. Үүнд: - Цагаандэлгэр сумын халуун ус ахуйн үйлчилгээний барилгын ажил

- Эрдмийн далай цогцолбор сургуулийн сантехникийн засвар

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хоол хүнсний материал нийлүүлэх

- Байгалийн ургамлын тооллого судалгааны ажил

- Шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамж

- Аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын заалнуудын тавилга

- Хүнс хөдөө аж ахуйн газрын барилгын засварын ажил бөгөөд III улирлын байдлаар тендерийн хүчинтэй хугацаанд хийгдээгүй худалдан авалт байхгүй байна.

1.5 “Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, гадна цэвэр усны ажил”-ын тендер шалгаруулалтыг 2018.09.25-нд зарласан бөгөөд “Ньюжен” ХХК-аас тус тендер шалгаруулалтын баримт бичигт өрсөлдөөн хязгаарласан байна үзэж гомдол гаргах

тухайгаа захиалагчид ирүүлсэн бөгөөд үнэлгээний хороо хуралдаж тус заалтыг хянан үзэж 2 багц болгон 2018.10.09-ны өдөр хугацааг сунган зарлаж зөрчлийг арилгасан болно.

1.6 2018 оны III улирлын байдлаар 6 тендер шалгаруулалтанд гомдол гарсан бөгөөд үүний 4 нь Сангийн яаманд, 2 нь ШӨХТГ-т гаргасан байна.


Гомдол шийдвэрлэлтийн байдал

	Тендер шалгаруулалтын нэр	Гомдол хүлээн авсан газар	Гомдол гаргагч ААН-ын нэр	Гомдол шийдвэрлэлтийн байдал
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хоол хүнсний материал худалдан авах	Сангийн яам	Ялгуум билигт ХХК	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй
2	Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв, эм эргэлтийн сангуудад эм эмнэлэгийн хэрэгсэл	ШӨХТГ	Монэнзим ХХК	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй
3	Байгалийн ургамлын тооллогын судалгааны ажлыг мэргэжлийн судалгаа хийх	Сангийн яам	Агнуур судлалын нийгэмлэг ТББ	Хүчингүй болгож дахин зарласан
4	Хүнс хөдөө аж ахуйн газрын барилгын засварын ажил	Сангийн яам	Баянгийн говь ХХК	Дахин үнэлгээ хийх
5	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх	ШӨХТГ	Газар сервис ХХК	Өрсөлдөөн хязгаарласан гэж үзсэн
6	Аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын заалны тавилга	Сангийн яам	Монтел ХХК	Хүчингүй болгож дахин зарлах

1.7

Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар:

2.1. 2018 онд тендер шалгаруулалтыг аймгийн хэмжээнд бүрэн цахим хэлбэрт оруулах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд Орон нутгийн өмчийн газраас гадна 14 сум 1 агентлагаас нийт 108 тендер шалгаруулалт цахим хэлбэрээр зарлагдсан байна.



Орон нутгийн өмчийн газраас tender.gov.mn цахим системийн болоод тоон гарын үсгийн талаарх сургалтыг 2018 оны 03 сарын 31-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтанд орон



нутгийн 25 аж ахуй нэгж хамрагдаж амжилттай зохион байгуулагдсан.

2.2 Одоогоор ерөнхий гэрээгээр худалдан авалт зохион байгуулагдаагүй байна.

Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар

3.1. Аймгийн 15 суманд орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөр 2018 онд нийт 3,9 тэрбум төгрөгийн 240 бараа, ажил худалдан авахаас төлөвлөгдсөн бөгөөд 2018.10.02-ны өдрийн байдлаар 154 худалдан авалтанд гэрээ байгуулагдаж сумдын худалдан авах ажиллагаа 64 хувийн биелэлттэй байна. Дээрх 154 худалдан авалтаас шууд



худалдан авах босго үнээс хэтэрсэн төсөвтэй тендер зарлах шаардлагтай 72 тендерийг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

2018 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр сумдын Засаг даргын орлогч нарт tender.gov.mn цахим системийн талаарх сургалтыг зохион байгуулж 2018 онд тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, дотоодын бараа бүтээгдэхүүн санал болгон этгээдэд давуу эрх олгож ажиллах талаар чиглэл өгч ажилласан.

Дөрөв. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаарх дүгнэлт, санал

4.1 Худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод явуулах зорилгоор:

“2018 онд Худалдан авах ажлын аймгийн төлөвлөгөө” болон зарлаж байгаа ц

1. Улсын хэмжээнд өдөр тутмын “Зууны мэдээ” сонинд

2. Сангийн яамны www.tender.gov.mn сайтад

3. Аймгийн **www.dundgovi.gov.mn** сайтад

4. Аймгийн Засаг даргын 7 хоног тутмын шуурхай мэдээллээр

5. Төлөвлөөг “Дундговийн амьдрал” сонинд тус тус иргэд, олон нийтэд зарлан мэдээлж байна.

Тайлан боловсруулсан: ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Адъяасүрэн

Хянасан: ОНӨГазрын дарга

С.Ууганбаяр

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР